



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2020 оны 5-р сарын 8-аас  
5-р сарын 14-ний байдлаар

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 5-р сарын 8-аас 5-р сарын 14-ний байдлаар

КОВИД-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн гаргаж буй гадаад орчны тойм мэдээллийн 9 дэх дугаарыг хүргэж байгааг хүлээн авна уу.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- ОУВС-ийн тэргүүн Кристилина Георгиева “дэлхий нийтээр хэрэглээ хумигдаж, **дэлхийн эдийн засгийн төлөв 4-р сарын төсөөллөөс<sup>1</sup> дордсон**” гэж 5-р сарын 12-ны өдрийн мэдэгдэлдээ дурдлаа. Мөн санхүүгийн зах зээлд цар тахлын нөлөөний 2 дахь давлагаа гарах эрсдэлтэйг анхааруулав. Түүнчлэн, хөгжиж буй орнуудыг хямралаас гаргахад нийт 2.5 их наяд ам.долларын санхүүгийн туслалцаа шаардлагатай гэж өмнөх сард үзэж байсан бол, энэ дүн ч өсөх хүлээлттэй байгааг мэдэгдэв.
- НҮБ-аас **дэлхийн эдийн засаг энэ онд 3.2 хувиар агших**, ирэх онд 3.4 хувиар сэргэх төсөөллийг 5-р сарын 13-нд зарлалаа. Уг төсөөллөөр дэлхийн нийтийн үйлдвэрлэл энэ онд 8.5 их наяд ам.доллартай тэнцэх хэмжээгээр буурах буюу 4 жилийн эдийн засгийн өсөлтийг алдсантай тэнцэх юм. Мөн цар тахлын улмаас энэ онд 34.3 сая хүн хэт ядуурлын шугамаас доош унах төлөвтэй байгаа бөгөөд үүний 56 хувь нь Африкийн орнуудад ажиглагдана гэж НҮБ үзжээ. Харин Дэлхийн банкнаас 5-р сарын 11-нд мэдэгдсэнээр цар тахлын улмаас нийт 40-60 сая хүн ядуурлын шугамаас доош орно гэж таамаглаж байна.
- **Roubini Global Economics** байгууллагаас **дэлхийн эдийн засаг 2020 онд 3.2 хувиар агших** шинэчилсэн төсөөллийг 5-р сарын 11-нд зарлалаа. Суурь төсөөлөлд ирэх жил вакцин гарах хүртэл вирусийн тархалт хязгаарлагдахуйц түвшинд хадгалагдах, хэрэглээ оны 2-р хагасаас сэргэхээр таамаглажээ. Харин муу хувилбарт зарим орнууд хөл хориог хэт эрт цуцалснаар КОВИД-19-ийн дэгдэлт дахин нэмэгдэж, W хэлбэрийн хямрал ажиглагдах бөгөөд дэлхийн эдийн засаг 2020 онд 4-6 хувиар агшиж болзошгүй гэж үзэж байна.
- КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор **хөгжиж буй орнуудын хувийн секторын ААН-үүд өр, төлбөрөө төлж чадахгүй, дефолт зарлах магадлал 2008 оны санхүүгийн хямралын үеэс ч илүү өндөр болж нэмэгдэхээр** байгааг Moody’s агентлагаас анхаарууллаа. Өнгөрсөн жил эрчимтэй хөгжиж буй орнуудын нийт 7 компани өндөр

<sup>1</sup> 4-р сарын дунд үед ОУВС-гаас дэлхийн эдийн засаг 2020 онд 3 хувиар агших төсөөллийг хийсэн.

эрсдэлтэй бондын эргэн төлөлтөө хийж чадалгүй, дефолт зарласан хувь нь 0.8% байсан бол энэ жил болон 2021 оны 3-р сарыг хүртэлх хугацаанд эрсдэлтэй бондын дефолт зарлах хувь 13.7% болж нэмэгдэнэ <sup>2</sup> гэж Moody's агентлаг таамаглаж байна.

- **“Их 20”-ийн бүлэг орлого багатай 73 улсын нийт 20 орчим тэрбум ам.доллартай тэнцэх зээлийн эргэн төлөлтийг ирэх он хүртэл хойшлуулах тохиролцоонд хүрлээ.** ОУВС-ийн мэдээлснээр хөгжиж буй эдийн засагтай орнуудын хөрөнгийн гадагшлах урсгал 100 тэрбум ам.доллар давж, цар тахлын улмаас хүндрэлд орсон 100 гаруй орнууд ОУВС-аас санхүүгийн тусламж хүсчээ.
- **АНУ-ын төсвийн алдагдал 4-р сард 738 тэрбум ам.долларт буюу түүхэн дээд түвшинд хүрэв.** Төсвийн орлого өмнөх жилээс 55 хувиар буурч 241 тэрбум ам.долларт хүрсэн бол төсвийн зарцуулалт 161 хувиар өсч 980 тэрбум ам.долларт хүрчээ. АНУ-ын ХҮИ-ийн инфляц 4-р сард хүлээлтээс 2 дахин бага буюу жилийн 0.3 хувьтай гарлаа.
- **ХНБ-ийн тэргүүн Жером Повел 5-р сарын 13-ны өдрийн илтгэлдээ Америкт 20 гаруй сая хүн ажлын байраа алдсаныг мэдэгдэв.** Жилийн 40 мянган ам.доллараас бага орлоготой иргэдийн 40% нь 3-р сард ажилгүй болжээ. Конгресс 2.9 триллион ам.доллар (ДНБ-ий 14%) буюу түүхэн дээд хэмжээний төсвийн багцыг маш богино хугацаанд баталсан нь эдийн засагт дэмжлэг болсон ч, цаашид бүтээмж, орлогын уналт үүсгэхгүйн тулд төсвийн бодлогын үүрэг чухал хэвээр байгааг онцлов.

<sup>2</sup> 2008 оны санхүүгийн хямралын оргил үед эрсдэлтэй бондын дампуурлын хувь 13.6 хувьд хүрч байв.

<sup>3</sup> Албан ёсны тоон статистик 5-р сарын 26-нд зарлагдана.

Харин төв банк бодлогын бүхий л хэрэгслээ ашиглахад бэлэн ч, санхүүжилтийн урсгалыг дэмжих замаар **зээлэх чадвартай** ч, төсвийн бодлогын адил **мөнгө зарцуулах** аргагүйг анхаарах хэрэгтэй гэв.

- **ОХУ-ын автомашины борлуулалт 4-р сард өмнөх оны мөн үеэс 72 хувиар буурав.** Энэ нь 2007 оноос хойш ажиглагдсан хамгийн том агшилт юм. Блүүмбергийн түүвэр судалгаагаар ОХУ-ын жижиглэн худалдааны борлуулалт 4-р сард 15 хувиар буурах урьдчилсан тооцоог хийжээ <sup>3</sup>. ОХУ-д вирусийн тархалт өндөр байгаа ч, эдийн засгийн алдагдлаа багасгахын тулд улс нийтийн хөл хориог 5-р сарын 12-нд цуцлаад байна<sup>4</sup>.
- Энэтхэг Улсын Засгийн газраас КОВИД-19-ийн тархалтыг удаашруулж, эдийн засгаа сэргээхэд зориулан 266 тэрбум долларын (ДНБ-ний 10 хувьтай тэнцэх) төсвийн багц санхүүжилтийг батлахаар зэхэж байгаагаа зарлав. Энэтхэг Улс хөл хорио тогтоосноос хойш 8 долоо хоног өнгөрч байгаа бөгөөд нийт 140 сая хүн ажлын байраа алдаад байгаа юм.

<sup>4</sup> Хэдийгээр улс даяар хөл хориог цуцалсан ч том хотуудын хөл хорио үргэлжлэх юм.

## 2 ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **БНХАУ-ын автомашины худалдаа** 2, 3-р саруудад 79, 40 хувиар тус тус буурсан бол **4-р сард** уналт эрс багасч, **5.5 хувиар буурсан** нь 2018 оны 6-р сараас хойших хамгийн анхны сарын өсөлт боллоо. Ийнхүү автомашины салбарын сэргэлт цаашид үргэлжлэх тохиолдолд өсөлт 2020 онд 25 хувиар саарахаар байсан бол, 15 хувь хүрч уналт нь багасахаар байгааг Хятадын автомашин үйлдвэрлэгчдийн холбооноос мэдээлэв. Автомашины агуулахууд дахь нөөц 4-р сард өмнөх сараас 6.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 5-р сарын эхний долоо хоногт автомашины худалдаа 32,006 нэгжид хүрч буурсан боловч, өмнөх долоо хоногоос 12 хувиар нэмэгдсэн нь салбарын сэргэлт алгуур үргэлжлэх хүлээлтийг бий болгож байна<sup>5</sup>.
- **Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбар дахь дотоодын хөрөнгө оруулалт** энэ оны эхний 3 сард 1.012 их наяд юань хүрч өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар буурсан хэдий ч, цаашид **алгуур сэргэх хүлээлттэй байна**. Хятадын Хөгжил Шинэтгэлийн Хороо 2, 3-р сард нийт 189.8 тэрбум юанийн дэд бүтцийн төслүүдийг баталсан нь өмнөх оны мөн үе (32.3 тэрбум юань)-ээс хэд дахин өндөр өсөлт байв. Шанхай хотын орон сууцны худалдаа 5 дахь долоо хоногтоо өсч 282,000м<sup>2</sup>-д хүрч өмнөх долоо хоногоос 5.3 хувиар нэмэгдлээ. Ийнхүү Хятадын томоохон хотуудад үл хөдлөх хөрөнгийн борлуулалт алгуур нэмэгдэж байгаа нь хэрэглэгчдийн итгэл сэргэснийг илтгэж байна.
- **КОВИД-19** өвчлөлөөс шалтгаалан эрэлт төдийлөн нэмэгдэхээргүй байгаа тул **коксжих нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнэ** болон **Хятадын эрчим хүчний нүүрсний үнэ бага түвшинд хадгалагдсан хэвээр байгааг** SXCoal 4-р сарын тайландаа мэдээлэв. Сүүлийн 2 сар дараалан буурч буй коксжих нүүрсний үнийг дэмжих хүрээнд Хятадын зарим боомтууд нүүрсний импортын хоригоо чангаруулаад байгаа бөгөөд зөвхөн худалдан авагч тал гаалийн хуудас бөглөснөөр тээврийг хүлээн авах болсон билээ. Мөн Засгийн газраас нүүрсний үнэ нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрүүдийг үйлдвэрлэлээ сайн дураараа бууруулахыг уриалж байна.
- БНХАУ, АНУ хоорондын харилцаа таагүй болж буй энэ үед **Хятадын Засгийн газраас АНУ-ын 79 нэр төрлийн бүтээгдэхүүнийг импортын тарифаас 1 жилийн хугацаанд чөлөөлөх шийдвэрийг** 5-р сарын 12-нд зарлалаа.
- **Хятадын төсвийн бодлого**: Төсвийн бодлогын хүрээнд тусгай зориулалттай Засгийн газрын бондын арилжаа болон орон нутагт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авснаар 2020 онд Хятадын Засгийн газар 4-5 их наяд юанийн төсвийн зарцуулалт хийх төлөвтэй байна. Хятадын Засгийн газраас 2-6-р саруудад ойролцоогоор 650 тэрбум юанийн хөнгөлөлтийг компаниудад олгохоор байна.

<sup>5</sup> Блүүмберг: [China's Auto Market Is Witnessing a V-Shaped Recovery](#)

Хятадын Ардын Их Хурал 5-р сарын 22-ны өдөр хуралдана. Тус хурлаар ДНБ-ий өсөлтийн тоон зорилтыг энэ онд цуцлах эсэх, төсвийн алдагдлын хэмжээ тусгай зориулалттай бонд олголтын квот зэргийг эцсийн байдлаар батлах хүлээлттэй байна. Блүүмбергийн шинжээчид 2005 оноос хойш ДНБ-ий 3 хувиас доогуур хадгалагдаж байсан төсвийн алдагдлыг 2020 онд ДНБ-ий 3.5 хувь, бонд олголтын квотыг 1.5-2 их наяд юань хүрнэ гэж таамаглаж байна.

- **Хятадын мөнгөний бодлого:** Хятадын Ардын Банк (ХАБ) энэ онд бодлогын хүүгээ 0.3-0.4 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байсан бол дэлхийн эдийн засгийн хямралаас үүдэн дотоод эдийн засагт ирэх дарамтыг саармагжуулахын тулд бодлогын хүүгээ 0.5-0.6 нэгж хувиар бууруулахаар байна гэж 5-р сарын 10-ны өдөр Мөнгөний бодлогын мэдэгдэлдээ онцоллоо<sup>6</sup>. ХАБ 2-р сараас хойш бодлогын хүүг 0.3 нэгж хувиар бууруулж 1 жилийн хугацаатай дунд хугацааны зээлийн хүүг (TMLF) 3.15 хувиас бууруулж 2.95 хувьд хүргэсэн.

- Тэгвэл 2-р улиралд бодлогын хүүг дахин 0.2 нэгж хувиар бууруулна гэж Блүүмбергийн шинжээчид таамаглаж байна. Түүнчлэн, Заавал байлгах нөөцийн хувийг 1 нэгж хувиар бууруулах шат дараатай бодлогын шийдвэр<sup>7</sup> 5-р сарын 15-аас хэрэгжиж эхэлснээр 200 тэрбум юанийн эх үүсвэр чөлөөлөгдөхөөр байна. Мөн цаашид дунд хугацааны зээлийн хүүг бууруулах, жижиг дунд бизнесүүдэд хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг дэмжих зэрэг арга хэмжээг авах хүлээлттэй байна.

<sup>6</sup> Блүүмберг: [PBOC Vows Stronger Pro-Growth Policy But Leaves Details](#)

<sup>7</sup> ХАБ-аас 4-р сарын 3-нд Заавал байлгах нөөцийн хувийг 1 нэгж хувиар 2 үе шаттайгаар бууруулах шийдвэрийг гаргаж, эхний удаагийнх 4-р сарын 15-с


хэрэгжиж эхэлсэн бол 2-р шат 5-р сарын 15-наас хэрэгжиж эхлэхээр байна.

**3 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ 2020 ОНЫ 5-Р САРД**

**Гадаад худалдаа:**


**Гадаад худалдааны эргэлт буурч, тэнцэл алдагдалтай гарлаа.** 2020 оны 4 дүгээр сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1318.3 сая ам.доллар (30.8%)-аар буурч, худалдааны тэнцэл 212.7 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад экспорт 1138.4 сая ам.доллар (45.3%)-аар, импорт 179.9 сая ам.доллар (10.2%)-аар тус тус буурсан байна.

*Зураг 1. Гадаад худалдааны эргэлтийн өсөлт, сараар*



*Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар*

*Зураг 2. Экспорт, импорт, тухайн сараар*



*Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар*

**2020 оны 4 дүгээр сард 337.8 сая ам.долларын экспорт, 424.8 сая ам.долларын импорт хийсэн байна. Энэ нь өмнөх сартай харьцуулахад 27.4% болон 3.2%-иар өссөн үзүүлэлт юм.**


Зарим нэр төрлийн барааны экспорт, импортын гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс дараах байдлаар буурчээ.

Барааны нэр	Экспорт		Импорт	
	сая \$	%	сая \$	%
Эрдэс бүтээгдэхүүн	-913.21	-43.1	-64.84	-15.8
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	-18.54	-74.2	-0.27	-0.2
Арьс ширэн бүтээгдэхүүн	-1.12	-17.9	-0.22	-11.4
Нэхмэлийн материал, эдлэл	-77.50	-72.3	1.41	5.3
Тээврийн хэрэгсэл, гэдгээрийн эд, анги	-0.80	-23.4	-83.49	-25.4
Мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	-15.03	-71.3	-3.59	-14.6



**Инфляц:**

**Зураг 3. Инфляц, сараар**




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Жилийн инфляц 4 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 4.7%, Улаанбаатар хотын хэмжээнд 5.3% буюу өмнөх 3 дугаар сараас буурлаа. Энэ нь КОВИД-19 цар тахлаас сэргийлэх хориг арга хэмжээтэй холбоотойгоор газрын болон агаарын тээврийн үйлчилгээ багасч, шатахууны үнэ буурсантай холбоотой байна.

**Хөрөнгийн зах:**

Хөрөнгө оруулагчид эрсдэлтэй багцаа зарж (sell off) илүү хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөнд эх үүсвэрээ байршуулж эхэлснээр **Монгол Улсын Засгийн газар болон компаниудын бондуудын үнэ унаж**, өгөөж 2020 оны 3 дугаар сараас эхлэн огцом өссөн. Тухайлбал уг бондуудын өгөөж 2020 оны 5 дугаар сарын 15-ны байдлаар өнгөрсөн сарын мөн үетэй харьцуулахад дунджаар 19.2% өсч, үнэ 2.2% буураад байна.

**Зураг 4. МУ-ын бондуудын өгөөж (%)**



Эх сурвалж: Монголбанк

**Зураг 5. Хөрөнгийн биржийн Top-20 индекс**




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

**Эдийн засгийн зогсонги байдлаас үүдэн Монголын хөрөнгийн захын идэвхжлийн бууралт үргэлжилж байна.** 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдөр энгийн арилжаагаар I, II, III ангиллын 16 хувьцаат компанийн 205,900,565 төгрөгийн үнийн дүн бүхий 5,842,546 ширхэг хувьцаа арилжигдсанаас 4 хувьцаат компанийн хувьцааны ханш өсч, 9 хувьцаат компанийн хувьцааны ханш буурсан бол 3 үнэт цаасны ханш тогтвортой байлаа. Улмаар ТОП-20 индексийн үзүүлэлт 16295.41 болж өнгөрсөн 7 хоногоос 1.0%, оны эхнээс 15.0%-иар буураад байна.

**Ажилгүйдлийн тэтгэмж:**

**Ажилгүйдлийн тэтгэмжид олгосон мөнгөн дүн өссөн байна.** 2020 он гарснаар ажилгүйдлийн тэтгэмжид олгосон мөнгөн дүнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40-44%-иар өссөн байна. Энэ үзүүлэлт нь 2019 оны эхний улиралд 10-34% байсан байна.

*Зураг 6. Ажилгүйдлийн тэтгэмж*



*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

**4 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ**

Улсын Их Хурлын 2020 оны 4-р сарын 29-ний чуулганы нэгдсэн хуралдаанаар “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа. Уг тогтоолд:

- Монгол Улсын урт хугацааны тогтвортой өсөлтөд дэмжлэг үзүүлж, үүсэх эрсдэлээс хамгаалах,
- Санхүүгийн чадвартай байх эрүүл, тогтвортой, зохистой засаглал бүхий банкны салбарыг бий болгох шинэчлэлийн хөтөлбөрийг гаргаж, хэрэгжүүлэх,
- Зээл, санхүүжилтийн хүү болон эх үүсвэрийн зардлыг бууруулах,
- Цар тахлын үед төрөөс нийгмийн шаардлагатай хэсэгт хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх,
- Жижиг дунд үйлдвэрийн зээлд батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх

- Улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх,
- Мөнгө хүүлэлтийг хязгаарлах замаар зээлдэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг нэн яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд багтжээ.

Түүнчлэн, төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагчдад зориулсан ипотекийн зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргах хүрээнд:

- Түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны тусгай хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх,
- Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх,
- Ноолуурын түүхий эдийн экспорт бүрдүүлэх, ноолуурын экспортыг дэмжих зорилгоор хилээр татваргүй гаргах, хөнгөлөлттэй зээл олгох, малчдын орлого болон үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор ноолуурын килограммын суурь үнэ дээр нэг килограмм тутамд 20 мянган



төгрөгийн урамшууллыг малчин бүрт олгох зэрэг заалтууд уг тогтоолд оров.

Засгийн газраас коронавирусын халдварт цар тахлын үед эдийн засгийг дэмжих хоёр дахь шатны хөтөлбөрөө 5-р сарын 6-ны өдөр танилцуулав. Энэ хүрээнд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготой дөрвөн ажил хийхээр болжээ. Үүнд:

1. 2020 оны дөрөвдүгээр сарын 1-ээс аравдугаар сарын 1-нийг хүртэл 0-18 насны хүүхэд бүрт сар болгон 100,000 төгрөг олгох;
2. 2020 оны тавдугаар сарын 1-ээс аравдугаар сарын 1-нийг хүртэл нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай бага орлоготой 122,000 хүнд сар бүр 16 мянган төгрөгийн хүнсний талон олгодгийг 32 мянган төгрөг, хүүхдэд 8 мянган төгрөг олгодгийг 16 мянга болгож нэмэгдүүлэх;

3. 2020 оны тавдугаар сарын 1-ээс аравдугаар сарын 1-нийг хүртэл нийгмийн халамжийн тэтгэврийг 100,000 төгрөгөөр нэмэгдүүлэх;
4. Малчдын орлого болон ноолуурын салбарын дотоод үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор малчин өрхүүдэд ноолуурын кг тутамд 20,000 төгрөгийн урамшуулал олгохоор болов.


Эдгээр дэмжлэгт нийт 793.6 тэрбум төгрөг зарцуулах бөгөөд үүнтэй холбогдуулан Засгийн газраас хоёр тогтоол баталлаа.

Цар тахлын тархалтын үед Нийгмийн халамжийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 5-р сарын 13-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрээр гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэний хүүхдэд 2020 оны аравдугаар сарын 1-н хүртэл хүүхдийн мөнгөн тэтгэмж олгохоор боллоо.

## 5 ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Өвчний тархалтыг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй хориг арга хэмжээнүүд нь газрын тосны эрэлт огцом буурснаар газрын тосны үнэ их хэмжээгээр сулраад байна. Үүнтэй холбоотойгоор газрын тосны үйлдвэрлэлийн гарцаа танах хэлцлийг ОПЕК-ийн Өргөтгөсөн бүлэг баталсантай зэрэгцэн газрын тосны үнэ сэргэж 30 ам.долларт хүрээд байна. Гэвч, эрэлтийн түвшин бага хэвээр байх хүлээлттэй байгаа тул үнийн түвшин бага хэвээр хадгалагдахаар байна. Харин зэсийн ханш өнгөрсөн нэг сарын хугацаанд аажмаар сэргэж нэг тонн зэсийн үнэ 5280 орчим ам.долларт хүрээд байна. Төмрийн хүдрийн хувьд сүүлийн нэг сарын хугацаанд харьцангуй тогтвортой 80-85 ам.долларт хэлбэлзэж байгаа бол алтны ханш өндөр хэвээр 1700-1730 ам.долларын хооронд хэлбэлзэж байна.

Зураг 7. Зэсийн үнэ



**Зэсийн үнэ.** Манай улсын гол экспортын бүтээгдэхүүнүүдийн нэг болох зэсийн үнэ КОВИД-19 цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор огцом унасан бөгөөд 3 дугаар сарын 23-ны байдлаар 4609 ам.долларт хүрч буурсан нь сүүлийн 4 жилийн хамгийн доод түвшин юм. Харин БНХАУ-н үйлдвэрүүдийн үйл ажиллагаа тогтмолжиж тус улсын зэсийн импорт өссөнтэй холбоотойгоор сүүлийн нэг сар гаруй хугацаанд зэсийн үнэ буцаж сэргэн 5250 орчим ам долларт хүрээд байна.


Зураг 8. Газрын тосны үнэ



**Газрын тосны үнэ.** 2020 оны эхэнд АНУ, Ираны зөрчлийн улмаас брент төрлийн газрын тосны ханш 70 орчим ам.долларт хүрсэн. КОВИД-19 цар тахал дэлхийн олон оронд эрчимтэй тархаж, улс орнууд хилийн хориг, хариу арга хэмжээ авснаар дэлхийн аялал жуулчлал, тээврийн салбарын үйл ажиллагаа хумигдаж, үүнийг дагаад түлш, шатахууны эрэлт буурч байна. Нөгөө талд, томоохон газрын тос нийлүүлэгч ОХУ,

Саудын Араб зэрэг улсууд үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх шийдвэр гаргасны улмаас дэлхийн зах зээл дээр газрын тосны илүүдэл үүсэж, 3 дугаар сард газрын тосны үнэ тасралтгүй буурсан. 5 дугаар сарын 1-ээс эхлэн ОПЕК-ийн Өргөтгөсөн бүлгийн газрын тосны гарц танах хэлэлцээр хэрэгжиж эхэлсэнтэй зэрэгцэн газрын тосны үнэ аажмаар сэргэж 30 ам.доллар орчимд хэлбэлзэж байна.


Зураг 9. Алтны ханш



**Алтны ханш.** Дэлхийн эдийн засагт аливаа хямрал, тодорхой бус байдал үүсэхтэй зэрэгцэн алтны ханш огцом өсдөг. Үүнтэй холбоотойгоор 2020 оны эхний улиралд 6.9 хувиар өссөн нь 6 улирал дараалан алтны үнэ өссөн үзүүлэлт юм. 3 дугаар сарын эхэн үеэс ихэнх улсуудын засгийн газар, төв банкууд КОВИД-19-ийн сөрөг үр нөлөөг бууруулах, эдийн засгаа дэмжих арга хэмжээг шийдэмгий авч хэрэгжүүлснээр алтны ханш 1500 орчим ам.долларт хүрсэн.

Гэвч сүүлийн 3 долоон хоногт АНУ болон зарим улсад вирусийн тархалт эрчимтэй нэмэгдэж, алт олборлогч зарим улсад хөл хорио тогтоож уурхайнуудын үйл ажиллагаа доголдсон зэрэг нь алтны ханшийг өдөөж 1700-1740 ам.долларт хэлбэлзэж байна. Энэ нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 36 хувиар буюу 470 ам.доллараар өндөр байна.

Зураг 10. Төмрийн хүдрийн үнэ



**Төмрийн хүдрийн үнэ.** 2019 оны 11 сараас төмрийн хүдрийн ханш тасралтгүй өссөөр 2020 оны эхний сард 95 ам.долларт хүрсэн. Дэлхийн нийтэд төмрийн хүдрийн импортын 70%-ийг бүрдүүлдэг Хятад улсад КОВИД-19-н улмаас цагаан сарын амралт урт хугацаанд үргэлжилж, аж үйлдвэрүүд зогсонги байдалд орсон нь төмрийн хүдрийн эрэлт буурахад нөлөөлсөн. Ингэснээр 2 дугаар сарын эхэнд төмрийн хүдрийн үнэ 15.3 хувиар огцом унаж, 78.3

ам.долларт хүрчээ. Гэвч төмрийн хүдрийн гол нийлүүлэгч Австрали улсад хар шуурга, Бразил улсад ихээр бороо орсонтой холбоотойгоор нийлүүлэлт тасалдсан нь төмрийн хүдрийн үнэ буцаж сэргэхэд нөлөөлжээ. Сүүлийн нэг сарын хугацаанд төмрийн хүдрийн үнэ харьцангуй тогтвортой 80-84 ам.долларын хооронд хэлбэлзэж байсан бол Бразил улсад шинэ коронавирусийн халдвар хурдтай тархаж, төмрийн хүдрийн нийлүүлэлтийн хувьд тодорхойгүй байдал үүсэхтэй зэрэгцэн өнгөрсөн 7 хоногт төмрийн хүдрийн ханш 2.8 хувиар өсөж, 88.4 ам.долларт хүрээд байна.

**Нүүрсний үнэ.** Далайн тээврээр худалдаалагддаг коксжих нүүрсний нийлүүлэлтэд тэргүүлэх үүрэгтэй оролцдог Австралийн коксжих нүүрсний ханш тавдугаар сар гарсаар огцом буурч эхэллээ. Тодруулбал (2020.04.30-ны байдлаар) коксжих нүүрсний үнэ тонн тутамдаа 130 ам.доллар байсан бол энэ сар гарсаар 107 ам.доллар/тонн болж ганц өдрийн дотор 17.5%-иар буураад байна<sup>8</sup>. Олон улсын зах зээлийн хувьд цахилгаан, дулааны эрэлт харьцангуй тогтвортой байгаагаас шалтгаалан нүүрсний үнэ бусад төрлийн эрчим хүчний түүхий эдтэй харьцуулахад бага хувиар суларч байна. Оны нийт дүнгээр 2020 онд нүүрсний үнэ 17 хувиар буурна хэмээн таамаглаж байна<sup>9</sup>.

<sup>8</sup> [www.mongolianminingjournal.com](http://www.mongolianminingjournal.com)


<sup>9</sup> Commodity Markets Outlook, April 2020, World Bank Group

## 6 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ГОЛЛОХ ИНДЕКС ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

### USD, S&P:

- Макро эдийн засгийн тааламжгүй мэдээнээс үл харгалзан хувьцааны индексүүд өссөөр байна. Энэ нь хөрөнгийн зах зээлийн оролцогчид 2020 оны 2-р хагаст эдийн засаг огцом “V” хэлбэрээр буцаж сэргэнэ гэсэн хүлээлттэй байгааг илтгэж байна. Гэвч эдийн засаг “V” хэлбэрээр сэргэх эсэх нь өдөр ирэх тусам эргэлзээтэй болж байна.
- Бодлогын хүүний болоод бусад санхүүгийн хэрэгслийн өгөөж түүхэн доод түвшинд хүрсэн энэ үед хувьцааны зах зээлээс өгөөж олохоор хөрөнгийн шилжилт явагдаж буйг илтгэж байна.

АНУ-ын ажилгүйдэл, S&P 500 индекс



### EUR:

- Тайлант хугацаанд евро ам.долларын эсрэг 0.1%-иар чангарч, 1.08 түвшинд хүрэв.
- Тайлант хугацаанд ам.долларын ханш голлох валютын эсрэг суларч, Евро бүсийн ихэнх улс хөл хориогоо суллаж байгаа нь ханшид эерэгээр нөлөөлөв.

### CNY:

- Тайлант хугацааны турш юань ам.долларын эсрэг 7.04-7.10 хооронд хэлбэлзэж, хугацааны эцэст 7.07 түвшинд хүрч хаагдсан байна.
- БНХАУ-АНУ хоорондын тарифын асуудал юанийн ханшид хамгийн ихээр нөлөөлөх ба энэ оны туршид юань ам.долларын эсрэг 7.05-7.15 хооронд арилжаалагдах таамагтай байна.

### JPY, Nikkei:

- 4-р сарын туршид иенийн ханш 107 түвшинг эвдэх оролдлого удаа дараа хийсний эцэст огцом 106.65 түвшинд хүрч чангарлаа. Ингэснээр энэ онд иен ам.долларын эсрэг хамгийн сайн үзүүлэлттэй “Их-10”-ын валют боллоо.
- Хөл хориог аажмаар бууруулах тухай хэлэлцэж буй нь хувьцааны зах зээлд эерэг дохио болж байна.

### GBP, FTSE:

- Тайлант хугацаанд фунт стерлинг нь ам.долларын эсрэг 0.3%-иар чангарч, 1.24 түвшинд хүрлээ.
- Тайлант хугацаанд Их Британи болон Евро бүсийн хөрөнгийн зах зээл АНУ-ын адилаар сэргэлээ.